**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/224 Ховд

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, харилцаа холбооны тухай хууулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилга, хот байгуулалтын Сайд болон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дөрөвдүгээр хавсралтын 6-д заагдсан Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга
С.Гантөмөр -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Л.Батбаяр -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Д.Даваасамбуу -Статистикийн хэлтсийн дарга

П.Эрдэнэчулуун – Мэргэжлийн хяналтын газрын дарга

Г.Цэен-Ойдов – Хотын захирагчийн ажлын албаны дарга

Л.Дорждэрэм – Хот тохижуулах газрын дарга

Н.Нансалмаа - Шим-Ус ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер

Н.Мөнхцэцэг–Дулааны “Бадамлах дөл” ХХК-ийн ерөнхий инженер

С.Чинзориг -"Ховд дулааны станц" ТӨХК-ийн ерөнхий инженер

У.Пүрэвдорж -"Ховд цахилгаан түгээх сүлжээ" ХХК- ний ерөнхий инженер

Д.Алтанхуяг –"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер

Б.Төгөлдөр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:З.Өмиртай – Аймгийн Ерөнхий архитектор бөгөөд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

2.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, үйл ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж тайлан, төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /С.Гантөмөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН